

БАТЛАВ.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД,  
ТОХИОЛДЛЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ  
ДАРГА  
2020 оны 03 сарын 02  
Д.САРАНГЭРЭЛ

ШИНЭ КОРОНАВИРУСТ ХАЛДВАРЫН ЭРСДЭЛИЙН ТҮВШИН "МАШ ӨНДӨР" ҮЕИЙН  
ТОХИОЛДЛЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ БЭЛЭН БАЙДАЛ, ХАРИУ АРГА  
ХЭМЖЭЭНИЙ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

| Д/д                        | Үйл ажиллагаа   | Хугацаа                                   | Хариуцах нэгж,<br>албан тушаалтан   | Хамтран<br>ажиллах<br>байгуулага<br>албан<br>тушаалтан | Хүрэх түвшин   |
|----------------------------|---|---|-------------------------------------|--|--|
| <b>1. Төлөвлөлтийн баг</b> |   |   |                                     |  |  |
| 1.1                        | Эрсдэлийн үнэлгээ (ЭҮ) хийж эрсдэлийн түвшинг тогтоох   | Тухай бүрт                                | Эрсдэлийн үнэлгээний хамтарсан баг* | Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар (ЭМГ)            | Улсын хэмжээнд аймаг, нийслэлийн Эрсдэлийн түвшин тодорхойлогдсон байна.                   |
| 1.2                        | Хариу арга хэмжээний төлөвлөгөөг тодотгон (ТТ) холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж батлуулах | ЭҮ-ний дараа тухай бүрт (72 цагийн дотор) | Төлөвлөлтийн баг                    | Аймаг, нийслэлийн ЭМГ, Эрүүл мэндийн байгууллагууд     | Салбарын болон аймаг, нийслэлийн түвшинд хариу арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан байна. |
| 1.3                        | Төлөвлөгөөг хэрэгжүүлэх төсөв, төлөвлөлт хийх   | ТТ + 7 хоногийн дотор                     | Санхүү, хөрөнгө оруулалтын баг**    | Аймаг нийслэлийн ЭМГ, Эрүүл                            | Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв   |

|     |  |   |  | мэндийн байгууллагууд   | эрүүл мэндийн байгууллагын түвшинд гарсан байна.                    |
|-----|--|---|--|---|---|
| 1.4 | Мэдээлэлд тандалт, дүн шинжилгээ, эрсдэлийн нөхцөл байдлын түргэвчилсэн болон явцын үнэлгээ хийх               | Тухай бүрт                              | ХӨСҮТ, ЗӨСҮТ                                       | Хариу арга хэмжээний баг, Тархварзүйн зөвлөх баг***               | Түргэвчилсэн үнэлгээ үндэсний түвшинд тогтмол хийгдсэн байна.       |
| 1.5 | Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх   | Тухай бүрт                              | Бүх баг  | Зөвлөх баг***, Аймаг, нийслэлийн ЭМГ, Эрүүл мэндийн байгууллагууд | Зөвлөгөө шуурхай, тогтмол өгөгдсөн байна.                           |
| 1.6 | Санхүүгийн дэмжлэг, хүмүүнлэгийн тусламж авах ажлыг зохион байгуулах   | Тухай бүрт                              | Төлөвлөлтийн баг, Санхүү, хөрөнгө оруулалтын баг** | Олон улсын болон хамтрагч байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүн    | Дэмжлэг, тусламжийг шаардлагатай чиглэлээр авсан байна.             |
| 1.7 | Багуудаас хийсэн ажлын явцын тайлан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг тодорхой хугацаанд авч байх | Тухай бүрт                              | Төлөвлөлтийн баг                                   | Бүх баг   | Явцын тайлан гарсан байна.  |
| 1.8 | Сургамж, дүгнэлт, санал бүхий тайлан боловсруулах  | Тайван цагийн горимд шилжсэн тохиолдолд | Төлөвлөлтийн баг                                   | Бүх баг, Аймаг, нийслэлийн ЭМГ, Эрүүл мэндийн байгууллагууд       | Тайлан нэгтгэгдэж сургамж, дүгнэлт бүхий гарын авлага гарсан байна. |

|                                    |  |                 |  |   |  |                |
|------------------------------------|--|-----------------|--|---|--|----------------|
| 1.9                                | Нийгмийг дайчилсан, санаа өгсөн, уриалсан, яамны бодлого, чиглэлийг тодорхой харуулсан материал бэлтгэж олон нийтэд хүргэх   | Тухай бүрт      | Төлөвлөлтийн баг   | Аймаг, нийслэлийн ЭМГ, Эрүүл мэндийн байгууллагууд      | Нийгэмд хандлага байна.  | зэрэг түгээсэн |
| 1.10                               | Шинэ коронавируст халдварын үед эмзэг бүлэг, эрсдэлт бүлэгт хандсан бодлого, төлөвлөлтийн арга хэмжээ авах   | Тухай бүрт      | Төлөвлөлтийн баг   | Аймаг, нийслэлийн ЭМГ, Эрүүл мэндийн байгууллагууд      | Хүн амд чиглэсэн бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.              |                |
| 1.11                               | Ажиллах хүч, хүний нөөцийн төлөвлөлтүүдийг хийж, санхүү хөрөнгө оруулалт болон хариу арга хэмжээний багт өгөх  | Тухай бүрт      | Төлөвлөлтийн баг   | Аймаг, нийслэлийн ЭМГ, Эрүүл мэндийн байгууллагууд      | Хүний нөөцийн бодлого, төлөвлөлт тодорхой болсон байна.                    |                |
| 1.12                               | Шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, урвалж, оношлуур, халдваргүйжүүлэх бодис, эмнэлгийн тоног төхөөрөмжийн нөөцийн судалгаа, тооцоо хийх | Тухай бүрт      | Санхүү, хөрөнгө оруулалтын баг**, Хариу арга хэмжээний баг | Аймаг, нийслэлийн ЭМГ, Эрүүл мэндийн байгууллагууд      | Шаардлагатай нөөцийн судалгаа, тооцоог хийсэн байна.                       |                |
| <b>2. Хариу арга хэмжээний баг</b> |  |                 |  |   |  |                |
| 2.1                                | Хамтарсан хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах   | 48 цагийн дотор | Хариу арга хэмжээний баг                                   | Эрүүл мэндийн байгууллага, Мэргэжлийн нийгэмлэг, холбоо | Хариу арга хэмжээний багийн төлөвлөгөө Төлөвлөлтийн багт хүргэгдсэн байна. |                |

|     |   |            |                          |  |   |
|-----|---|------------|--------------------------|--|---|
| 2.2 | Хариу арга хэмжээг зохион байгуулж, мэргэжлийн удирдлага арга зүйгээр хангах                              | Тухай бүрт | Хариу арга хэмжээний баг | Зөвлөх баг***, Эрүүл мэндийн байгууллага, Мэргэжлийн нийгэмлэг, холбоо | Мэргэжил зүйгээр тухай бүрт хангагдсан байна.   |
| 2.3 | Тархалтын цар хүрээ, үйл явдлын нөхцөл, шалтгааныг тогтоох, тандалт, судалгаа шинжилгээ хийх              | Тогтмол    | Хариу арга хэмжээний баг | ХӨСҮТ, ЗӨСҮТ, НЭМҮТ, Зөвлөх баг***, Мэргэжлийн нийгэмлэг, холбоо       | Тандалт, судалгаа шинжилгээ тогтмол хийгдсэн байна.   |
| 2.4 | Шаардлагатай тохиолдолд хөл хорио, хязгаарлалтын дэглэм тогтоох санал боловсруулах                        | Тухай бүрт | Хариу арга хэмжээний баг | Зөвлөх баг***, Аймаг, нийслэлийн ЭМГ                                   | Багийн удирдлага дор өвчтөнг эмнэлэгт хүргэх, эмчлэх үйл ажиллагаа төлөвлөгөөний дагуу хийгдэж эхэлсэн байна. |
| 2.5 | Нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээг зохион байгуулах, лабораторийн оролцоог хангах | Тогтмол    | Хариу арга хэмжээний баг | Аймаг, нийслэлийн ЭМГ, Эрүүл мэндийн байгууллагууд                     | Тусламж, үйлчилгээ оновчтой зохион байгуулагдаж, байгууллагуудын оролцоо бүрэн хангагдсан байна.              |
| 2.6 | Голомтыг цомхотгох, таслан зогсоох арга хэмжээ авах   | Тухай бүрт | Хариу арга хэмжээний баг | Аймаг, нийслэлийн ЭМГ, Эрүүл   | Тухай бүрт голомтыг цомхотгон дарж,   |

|   |   |          |   |  |            |                          |  |  |
|---|---|----------|---|--|------------|--------------------------|--|--|
|   |   |          |   |  | Тухай бүрт | Хариу арга хэмжээний баг | мэндийн байгууллагууд                              | хариу арга хэмжээг авсан байна.  |
| 2.7   | Халдварын хяналт, сэргийлэлтийн нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж, халдварын хяналт, сэргийлэлтийн багийг байгуулан ажиллуулах |          |   |  |            |                          | Аймаг, нийслэлийн ЭМГ, Эрүүл мэндийн байгууллагууд | Халдварын хяналт, сэргийлэлтийн баг байгуулагдаж, төлөвлөгөөний дагуу ажилласан байна. |
| <b>3. Эрсдэлийн үеийн харилцаа холбооны баг**</b> |   |          |   |  |            |                          |  |  |
| 3.1   | Хүн ам, зорилгот бүлгийн дундах коронавируст халдварын ойлголт, хандлагыг тандан судлах   | Өдөр бүр | Эрсдэлийн үеийн харилцаа холбооны баг** |  |            |                          | НЭМҮТ, Төрийн бус байгууллага                      | Судалгаа хийгдсэн байна.   |
| 3.2   | Олон улсын хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд тандалт хийж, шийдвэр гаргагч нарыг мэдээллээр хангах                                     | Тогтмол  | Эрсдэлийн үеийн харилцаа холбооны баг** |  |            |                          | Дэлхийн эрүүл мэндийн байгууллага                  | Мэдээлэл түгээгдсэн хүргэсэн байна.  |
| 3.3   | 11-323002 дугаарын утсыг автомат хариулагч (call-pro) үйлчилгээнд холбож, зөвлөгөө мэдээлэл өгөх                                  | Тогтмол  | Эрсдэлийн үеийн харилцаа холбооны баг** |  |            |                          | ОНХТШУХ  | Зөвлөгөө, мэдээлэл түгээгдсэн хүргэсэн байна.  |
| 3.4   | Коронавируст халдварын нөхцөл байдлын мэдээг онлайн хяналтын самбар (dashboard)-т байршуулах, шинэчлэх                            | Тогтмол  | Эрсдэлийн үеийн харилцаа холбооны баг** |  |            |                          | ОНХТШУХ<br>ЭМЦМХ<br>Монмап ХХК                     | Хяналтын самбар ажиллуулсан байна.   |
| 3.5   | Эрүүл мэндийн яамны цахим хуудсыг автомат хариулагчтай (чат пот) болгох   | Тогтмол  | Эрсдэлийн үеийн харилцаа холбооны баг** |  |            |                          | ОНХТШУХ<br>ЭМЦМХ                                   | Автомат хариулагч ажилласан байна.   |
| 3.6   | Эрүүл мэндийн яамны цахим хуудсанд COVID-19 дэд цэс ажиллуулах  | Тогтмол  | Эрсдэлийн үеийн харилцаа холбооны баг** |  |            |                          | ОНХТШУХ<br>ЭМЦМХ                                   | Цахим хуудас ажиллуулсан байна.  |
| 3.7   | Онлайн хэвлэлийн бага хурал хийх  | Тогтмол  | Эрсдэлийн үеийн харилцаа холбооны баг** |  |            |                          | ОНХТШУХ<br>ЭМЦМХ                                   | Онлайн хурал хийгдсэн байна.   |

|      |  |            |   |                               |   |
|------|--|------------|---|-------------------------------|---|
| 3.8  | Коронавируст халдварын сэжигтэй тохиолдол, ажиглалтад байгаа хүмүүсийн нэгдсэн мэдээллийг гаргах, тархвар зүйн судалгаа хийх | Тогтмол    | Эрсдэлийн үеийн харилцаа холбооны баг** | ХӨСҮТ                         | Тархварзүйн судалгаа хийгдсэн байна.                    |
| 3.9  | Иргэдэд коронавируст халдварын талаар инфографик, шторк бэлтгэн хүргүүлэх  | Тухай бүрт | Эрсдэлийн үеийн харилцаа холбооны баг** | НЭМҮТ, Төрийн бус байгууллага | Инфографик шторк бэлтгэн түгээсэн байна.                |
| 3.10 | Ард иргэдэд өөрийгөө хамгаалж чадна гэсэн итгэлийг төрүүлэх, урьдчилан сэргийлэх аргуудыг сурталчлах                         | Тухай бүрт | Эрсдэлийн үеийн харилцаа холбооны баг** | НЭМҮТ, Төрийн бус байгууллага | Сурталчилгаа хийгдсэн байна.                            |
| 3.11 | Телевизээр хийх мэдээллийн тоо, агуулгад үнэлгээ хийж, зорилтот нэвтрүүлэг хийх  | Тухай бүрт | Эрсдэлийн үеийн харилцаа холбооны баг** | НЭМҮТ, Төрийн бус байгууллага | Нэвтрүүлэг хийгдсэн байна.                              |
| 3.12 | Иргэдэд зөвлөгөө өгөх "Нээлттэй 24 цагийн утас" ажиллуулах   | Тухай бүрт | Эрсдэлийн үеийн харилцаа холбооны баг** | Холбогдох байгууллагууд       | Утас ажилласан байна.                                   |
| 3.13 | Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн мэдээлэл, сурталчилгаа хийх   | Тухай бүрт | Эрсдэлийн үеийн харилцаа холбооны баг** | Холбогдох байгууллагууд       | Мэдээлэл, сурталчилгаа хийгдсэн байна.                  |
| 3.14 | Коронавируст халдварын цаг үеийн мэдээллээр хэвлэлийн болон цахим хурал хийх   | Тогтмол    | Эрсдэлийн үеийн харилцаа холбооны баг** | ОНХТШУХ                       | Олон нийтэд хандсан мэдээлэл тухай бүрт хийгдсэн байна. |
| 3.15 | Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчинд мониторинг хийж, тухай бүр нь арга хэмжээ авах                         | Тогтмол    | Эрсдэлийн үеийн харилцаа холбооны баг** | ОНХТШУХ<br>НЭМҮТ              | Мониторинг хийж, хариу арга хэмжээ авсан байна.         |
| 3.16 | Хүн амд зориулсан цаг үеийн мэдээ, мэдээллийг тогтмол явуулах  | Тогтмол    | Эрсдэлийн үеийн харилцаа холбооны баг** | ОНХТШУХ<br>ЭМБ-ууд            | Мэдээлэл тогтмол, шуурхай өгөгдсөн байна.               |

|  |   |            |   |   |  |
|--|---|------------|---|---|--|
| 3.17                                       | Салбар хоорондын мэргэжлийн байгууллагатай хамтран цахим хурал, лайв, ярилцлага хийх  | Тухай бүрт | Эрсдэлийн үеийн харилцаа холбооны баг** | Хэвлэл мэдээллийн болон бусад хамтрагч байгууллага            | Хэвлэлийн бага хурал, цахим хурал тухай бүрт зохион байгуулагдсан байна. |
| 3.18                                       | Коронавируст халдварын нөхцөл байдлын талаар мэдээлэл бэлтгэн холбогдох байгууллагад хүргүүлэх  | Тогтмол    | Эрсдэлийн үеийн харилцаа холбооны баг** |   | Мэдээлэл тогтмол, шуурхай хүргэгдсэн байна.                              |
| 3.19                                       | Үүрэн телефоны хэрэглэгчдэд зөвлөмж мессеж боловсруулан хүргэх, сурталчилгааны ЛЕД дэлгэцээр шторк, инфографик явуулах                | Тогтмол    | Эрсдэлийн үеийн харилцаа холбооны баг** | Харилцаа холбооны газар                                       | Мэдээлэл түгээгдсэн хүргэсэн байна.                                      |
| 3.20                                       | Коронавируст халдварын эмнэлзүй, урьдчилан сэргийлэлт, хариу арга хэмжээний талаар мэргэжлийн эмч нарын цуврал зөвлөгөө гарган түгээх | Тогтмол    | Эрсдэлийн үеийн харилцаа холбооны баг** | Эрүүл мэндийн байгууллагууд                                   | Цуврал зөвлөгөө өгсөн байна.   |
| <b>4. Санхүү, хөрөнгө оруулалтын баг**</b> |   |            |   |   |  |
| 4.1  | Эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд шаардагдах зардлын тооцоог гаргах, тодотгох   | Тухай бүрт | Санхүү, хөрөнгө оруулалтын баг**        | Сангийн яам, Аймаг, нийслэлийн ЭМГ, Эрүүл мэндийн байгууллага | Зардлын тооцоо гарч, санхүүжилт шийдэгдсэн байна.                        |
| 4.2  | Хуваарийн дагуу нөөцийг бүрдүүлэх, хуваарилах, зарцуулалтад хяналт тавих  | Тухай бүрт | Санхүү, хөрөнгө оруулалтын баг**        | Аймаг, нийслэлийн ЭМГ, Эрүүл                                  | Хуваарийн дагуу нөөцийн хуваарилалт хийгдсэн байна.                      |

|     |  |            |                                  |   | мэндийн байгууллага  |  |
|-----|--|------------|----------------------------------|---|--|--|
| 4.3 | Хүний нөөцийг төлөвлөлтийн дагуу дайчлан ажиллуулах  | Тухай бүрт | Санхүү, хөрөнгө оруулалтын баг** | ЭМЯ-ТЗУГ, ЭМХТ  | Шаардагдах хүний нөөцийн дайчилгааны хуваарь гарсан байна. |  |
| 4.4 | Дайчлагдан ажиллаж байгаа бие бүрэлдэхүүний ажилласан цагийг бүртгэх, цалин, нэмэгдэл хөлс, урамшууллыг тооцож олгох | Тухай бүрт | Санхүү, хөрөнгө оруулалтын баг** | Аймаг нийслэлийн ЭМГ, Эрүүл мэндийн байгууллага             | Холбогдох цалин хөлс, урамшууллыг олгосон байна.           |  |
| 4.5 | Багуудын үйл ажиллагааг хэвийн явуулах байр, техник, тоног төхөөрөмжөөр хангаж, дэд бүтцийг бий болгох               | Тухай бүрт | Санхүү, хөрөнгө оруулалтын баг** | ЭМЯ-ТЗУГ, Аймаг, нийслэлийн ЭМГ, Эрүүл мэндийн байгууллага  | Багуудын үйл ажиллагаа хэвийн явагдсан байна.              |  |
| 4.6 | Дайчлагдан ажиллаж байгаа бие бүрэлдэхүүнийг заавар, журмаар хангах, түргэвчилсэн сургалт зохион байгуулах           | Тухай бүрт | Санхүү, хөрөнгө оруулалтын баг** | Зөвлөх баг***, Хариу арга хэмжээний баг, ХӨСҮТ, ЗӨСҮТ, ЭМХТ | Сургалт зохион байгуулагдсан байна.                        |  |
| 4.7 | Санхүүгийн тайлан, тооцоог багуудын удирдлагад танилцуулах   | Тухай бүрт | Санхүү, хөрөнгө оруулалтын баг** | Аймаг, нийслэлийн ЭМГ, Эрүүл мэндийн байгууллага            | Тайлан тооцоо бүрэн дуусч, танилцуулагдсан байна.          |  |
| 4.8 | Шаардлагатай баримт бичгийг хувилах, олшруулах, тараах, устгах, баримтжуулах, архивлах                               | Тухай бүрт | Санхүү, хөрөнгө оруулалтын баг** | Бүх баг   | Холбогдох баримт бичгүүд архивлагдсан байна.               |  |



\* - Эрсдэлийн үнэлгээний хамтарсан баг нь Шадар сайдын 2017 оны “Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн салбар хоорондын мэдээлэл солилцох, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах журам батлах тухай” 08 дугаар тушаалаар зохицуулагдана.

\*\* - Шадар сайдын 2017 оны 08 дугаар тушаалаар баталсан “Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн салбар хоорондын мэдээлэл солилцох, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах журам батлах тухай” болон Эрүүл мэндийн сайдын 2020 оны “Тохиолдлын удирдлагын тогтолцоонд шилжих тухай” А/132 дугаар тушаалд заасан багийг дараах нэршлээр ойлгоно.

|   |  |
|---|--|
| Шадар сайдын 2017 оны “Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн салбар хоорондын мэдээлэл солилцох, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах журам батлах тухай” 08 дугаар тушаал | Эрүүл мэндийн сайдын 2020 оны “Тохиолдлын удирдлагын тогтолцоонд шилжих тухай” А/132 дугаар тушаал |
| Санхүү, нөөцийн баг   | Санхүү, хөрөнгө оруулалтын баг   |
| Эрсдэлийн мэдээлэл харилцааны баг   | Эрсдэлийн үеийн харилцаа холбооны баг  |

\*\*\* - Тархварзүйн зөвлөх багийн бүрэлдэхүүн, ажиллах чиглэл нь Эрүүл мэндийн сайдын 2020 оны 02 дугаар сарын 03 өдрийн “Тархварзүйн зөвлөх багийн бүрэлдэхүүн, ажиллах чиглэл батлах тухай” А/50 дугаар тушаалаар баталсан.

\*\*\* - Эмнэлзүйн зөвлөх багийн бүрэлдэхүүн, ажиллах чиглэл нь Эрүүл мэндийн сайдын 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн “Эмнэлзүйн зөвлөх багийн ажиллах журам, чиглэл батлах тухай” А/32 дугаар тушаалаар баталсан.

Товчилсон үгийн жагсаалт:

ЭҮ - Эрсдэлийн үнэлгээ;

ТТ - Тодотгосон төлөвлөгөө;

ТУТ - Тохиолдлын удирдлагын тогтолцоо;

ЭМЯ - Эрүүл мэндийн яам;  
ТЗУГ - Төрийн захиргааны удирдлагын газар;  
ОНХТШУХ - Олон нийттэй харилцах, тандалт, шуурхай удирдлагын хэлтэс;  
ЭМГ - Эрүүл мэндийн газар;  
ХӨСҮТ - Халдварт өвчин судлалын үндэсний төв;  
ЗӨСҮТ - Зоонозын өвчин судлалын үндэсний төв;  
НЭМҮТ - Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв;  
ЭМХТ - Эрүүл мэндийн хөгжлийн төв;  
ЦЕГ - Цагдаагийн ерөнхий газар;  
ТЕГ - Тагнуулын ерөнхий газар.